

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн  
байнгын хорооны 2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдрийн ..... дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

### НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Эрдэнэцогт <b>Ургийн овог:</b> Жадран <b>Нэр:</b> Чулуунцэцэг <b>Хүйс:</b> Эмэгтэй <b>Төрсөн он:</b> 1986 <b>Төрсөн газар:</b> Ховд аймаг, Мөст сум <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг [REDACTED]
1.2	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <input type="radio"/> Тийм
1.3	<b>Насны дээд хязгаар</b> Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <input type="radio"/> Үгүй
1.4	<b>Шүүгчийн албан тушаал</b> Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <input type="radio"/> Үгүй
1.5	<b>Улс төрийн болон намын удирдах албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <input type="radio"/> Үгүй
1.6	<b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <input type="radio"/> Үгүй
1.7	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. <input type="radio"/> Үгүй
1.8	<b>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус</b>

	<p><b>гишүүнээр томилохоос татгалзаж байсан</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>○ Үгүй</p>
--	---

## ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/ Тусад нь бичиж оруулав.</p>
-----	--

## ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p><b>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</b></p> <p><b>Албан тушаалын нэр:</b> 2020 оноос “Өмгөөллийн Оч Легал Адвокейтс” хуулийн фирмийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал</p> <p><b>Ажлын газрын хаяг:</b> Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Нийслэл хүрээ гудамж, “Акояа центр”, 5 дугаар давхар, 5013 тоот</p> <p><b>Ажилласан хугацаа:</b> 6 жил</p> <p><b>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:</b> “Өмгөөллийн Оч Легал Адвокейтс” хуулийн фирмийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлын хувьд фирмийн стратеги төлөвлөлт, өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, үйлчлүүлэгчийн харилцаа, хууль зүйн үйлчилгээний чанар, эрсдэлийн удирдлагыг хариуцан ажиллаж байна.</p> <p>Тус албан тушаалын хүрээнд иргэн, захиргаа, эрүүгийн хэрэг, маргаанд өмгөөлөгч, төлөөлөгчөөр оролцож, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн фирмээс боловсруулан гаргах албан бичиг, эрх зүйн баримт бичиг, гэрээ, тайлбар, дүгнэлтийн хууль зүйн үндэслэл, агуулга, найруулга, хэлбэрийн шаардлагыг хянах, хууль зүйн үйлчилгээний чанар болон мэргэжлийн ёс зүйн хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.</p> <p>Түүнчлэн үйлчлүүлэгчтэй байгуулах гэрээ, төлбөр тооцоо, мэдээллийн нууцлал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг зохион байгуулж, зөвлөх үйлчилгээний гэрээний үндсэн дээр хамтран ажилладаг хувийн эрх зүйн хуулийн этгээдүүдэд гэрээ, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хянах, үйл ажиллагааны эрх зүйн нийцлийг хангах, хууль зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг.</p> <p><b>Хамтран ажиллаж байсан болон ажил хэргийн харилцаатай хүмүүс</b></p> <p>1. <b>Нэр:</b> Д.Оргил <b>Албан тушаал, байгууллага:</b> “Өмгөөллийн Оч Легал Адвокейтс” хуулийн фирмийн өмгөөлөгч <b>Харилцааны төрөл:</b> Хуулийн этгээдийг хамтран үүсгэн байгуулсан <b>Утас:</b> [Redacted] <b>Цахим шуудан:</b> <a href="mailto:orgil.davaasuren@gmail.com">orgil.davaasuren@gmail.com</a> <b>Ажлын газрын хаяг:</b> Хан-Уул дүүрэг, [Redacted]</p>

2. Нэр: П.Нямсүрэн  
**Албан тушаал, байгууллага:** Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч  
**Харилцааны төрөл:** Хамтран ажиллаж байсан, [REDACTED]  
**Цахим шуудан:** nyamsuren.purevdorj@judges.mn  
**Ажлын газрын хаяг:** Налайх [REDACTED]
  
3. Нэр: Н.Наранбаатар  
**Албан тушаал, байгууллага:** “Жэмма Монголиа” ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
**Харилцааны төрөл:** Хамтран ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай  
**Утас:** [REDACTED]  
**Цахим шуудан:** naranbaatar@gemmamongolia.mn  
**Ажлын газрын хаяг:** Баянгол дүүрэг, [REDACTED]  
[REDACTED]
  
4. Нэр: П.Цэдэн-Иш  
**Албан тушаал, байгууллага:** IRIM судалгааны байгууллагын судлаач, зохицуулагч  
**Харилцааны төрөл:** Хамтран ажиллаж байсан  
**Утас:** [REDACTED]  
**Цахим шуудан:** Tsedenish-ish@irim.mn  
**Ажлын газрын хаяг:** Сүхбаатар дүүрэг, [REDACTED]  
[REDACTED]
  
5. Нэр: Э.Дэлгэрцэцэг  
**Албан тушаал, байгууллага:** гэрээт нягтлан бодогч  
**Харилцааны төрөл:** ажил хэргийн харилцаатай  
**Утас:** [REDACTED]  
**Цахим шуудан:** [deegii\\_93@yahoo.com](mailto:deegii_93@yahoo.com)  
**Ажлын газрын хаяг:**

2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Улсын дээд шүүхээс шүүхэд төлөөлөх эрхийг бүртгэж, 13-1487 дугаартай гэрчилгээ олгосон. Уг эрхийн дагуу МУБИС-д эрх зүйн хичээл зааж, багшлахын зэрэгцээ 2014 оноос хойш өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, иргэн, захиргаа, эрүүгийн хэрэг, маргаанд өмгөөлөгч, төлөөлөгчөөр оролцож ирсэн. Өмгөөлөгчөөр ажилласан байдлыг нотлох баримт болгон холбогдох шүүхийн шийдвэрүүдийг хавсаргав.

○

### 3.2 ЭРХ ЗҮЙЧЭЭС БУСАД МЭРГЭЖЛЭЭР ЭРХЭЛСЭН АЖИЛ

- 2008 оноос Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуульд эрх зүйн багш  
2008 оны 09 дүгээр сараас Монгол Улсын Боловсролын Их Сургуульд эрх зүйн багшаар ажиллаж, Эрх зүйн онол, Иргэний эрх зүй, Захиргааны эрх зүй, Боловсролын эрх зүй зэрэг хичээлийг тогтмол зааж ирсэн. Боловсролын эрх зүйн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан бөгөөд бакалавр, магистр, докторын түвшний сургалтад хичээл заах, эрх зүйн хичээлийн хөтөлбөр боловсруулах, оюутан, суралцагчийн судалгааны ажил удирдах, зөвлөгөө өгөх, шүүмж хийх зэргээр сургалт, судалгааны үйл ажиллагаанд оролцож байна.

Түүнчлэн магистрын түвшний судалгааны ажил удирдах, магистрын ажилд шүүмж өгөх, хамгаалалтын үйл ажиллагаанд оролцох зэргээр мэргэжлийн болон эрдэм

	<p>шинжилгээний чиг үүргийг хэрэгжүүлж байна. Мөн Улс төр, эрх зүйн боловсролын магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.</p> <p><b>Ажил олгогч:</b> МУБИС-ийн НХУС-ийн захирал, профессор Н.Мягмарцоож  <b>Хаяг:</b> МУБИС-ийн хичээлийн 4 дүгээр байр, 505 тоот  <b>Утасны дугаар:</b> [REDACTED]  <b>Цахим шуудан:</b> myagmartsooj@msue.edu.mn</p> <p><b>2023 оноос МУБИС-ийн Төв ёс зүйн хорооны даргаар томилогдон ажилласан.</b></p> <p><b>Ажил олгогч:</b> МУБИС-ийн ректор, профессор Б.Батбаатар  <b>Хаяг:</b> МУБИС-ийн хичээлийн 1 дүгээр байр, 201 тоот  <b>Утасны дугаар:</b> [REDACTED]  <b>Цахим шуудан:</b> batbaatar@msue.edu.mn</p>
3.3	<p><b>МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО, БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАЛААР</b></p> <p><b>1. Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч</b>          Гишүүн болсон огноо: 2014.07.07          Гишүүнчлэл хүчинтэй.          Эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг: Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчийн хувьд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд оролцож, хуульчийн мэргэжлийн ёс зүй, хууль дээдлэх зарчим, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх үүргийг баримтлан ажиллаж ирсэн.          Гишүүний үүргийн хэрэгжилтийн талаар: Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчийн хувьд холбооны дүрэм, журамд заасан гишүүний үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн.</p> <p><b>2. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч</b>          Гишүүн болсон огноо: 2014.01.24          Гишүүнчлэл хүчинтэй.          Эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг: Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчийн хувьд өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.          Гишүүний үүргийн хэрэгжилтийн талаар: Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчийн хувьд холбооны дүрэм, журамд заасан гишүүний үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн.</p>

**ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ**

4.1	<p><b>ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ</b></p> <p><b>НЭГ. “ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА”</b></p> <p><b>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:</b> “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн харьцуулсан судалгаа” судалгааны ажил, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын захиалгаар, 2025 он.</p> <p><b>Үйл ажиллагааны гол агуулга:</b> Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын агуулга, олон улсын хүний эрхийн стандарт, түүнчлэн ХБНГУ, БНФУ, ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, Гүрж, Турк зэрэг улсын эрүүгийн хууль дахь холбогдох зохицуулалтыг харьцуулан судалсан.</p>
-----	---

Судалгааны хүрээнд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, хүндрүүлэх нөхцөл, эрүүгийн хариуцлага, ял шийтгэлийн зохицуулалт, хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг дүгнэж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх талаар санал боловсруулсан.

**Үйл ажиллагааны үр дүн:** Судалгааны тайланг боловсруулж, гэрээний дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст хүлээлгэн өгсөн. Мөн судалгааны үр дүнг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Төрийн ордонд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, холбогдох Ажлын хэсэг, Хүний эрхийн Үндэсний Комиссоос хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн олон улсын харьцуулсан судалгаа” сэдвээр илтгэн хэлэлцүүлсэн.

<https://www.parliament.mn/nn/74745/>

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Нэр:** Б.Энхболд

**Албан тушаал, байгууллага:** Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [b.enkhbold8410@gmail.com](mailto:b.enkhbold8410@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, [Хүчингүй]

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс:**

**1. Нэр:** И.Мөнхбаяр

**Албан тушаал, байгууллага:** ХЭҮК-ийн референт

**Харилцааны төрөл:** Судалгааны ажлын хүрээнд хамтран ажилласан

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [ismunkhbayar@gmail.com](mailto:ismunkhbayar@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, [Хүчингүй]

**2. Нэр:** Д.Оргил

**Албан тушаал, байгууллага:** “Өмгөөллийн Оч Легал Адвокейтс” хуулийн фирмийн өмгөөлөгч

**Харилцааны төрөл:** Хуулийн этгээдийг хамтран үүсгэн байгуулсан, судалгааны ажлын хүрээнд хамтран ажилласан

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [orgil.davaasuren@gmail.com](mailto:orgil.davaasuren@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Хан-Уул дүүрэг, [Хүчингүй]

**3. Нэр:** П.Нямсүрэн

**Албан тушаал, байгууллага:** Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч

**Харилцааны төрөл:** Хамтран ажиллаж байсан

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [nyamsuren.purevdorj@judges.mn](mailto:nyamsuren.purevdorj@judges.mn)

**Ажлын газрын хаяг:** Налайх дүүрэг, [Хүчингүй]

## **ХОЁР. НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа, Захиргааны хэргийн шүүх, 2024–2025 он.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Өмгөөллийн тухай хуулийн 29.3-т заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд боловсролын салбарт гарсан захиргааны акт болон захиргааны хэм хэмжээний актыг шүүхээр хянуулах, нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд Төв аймгийн Засаг даргын гаргасан орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийг өөрчлөн байгуулахтай холбоотой захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж,

захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа оролцогчийг сонсох, нөхцөл байдлыг тогтоох ажиллагааг хэрэгжүүлсэн эсэх, мөн боловсролын байгууллагыг өөрчлөн байгуулах асуудлаарх эрх хэмжээний зааг, хууль хэрэглээний тодорхойгүй байдлыг шүүхээр хянуулсан.

Мөн Боловсролын сайдын баталсан “Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтыг хүчингүй болгуулах нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргаж, захиргааны хэм хэмжээний акт батлахдаа санал авах, нөлөөллийн шинжилгээ хийх, эрх ашиг нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг хуульд заасан ажиллагаа бүрэн хэрэгжсэн эсэхийг шүүхээр хянуулсан. Уг маргаан нь боловсролын салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг хөндлөнгийн шүүхийн хяналтад оруулсан жишиг ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Төв аймгийн боловсролын байгууллагын өөрчлөн байгуулалттай холбоотой маргааны явцад захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаа, оролцогчийн эрх, боловсролын байгууллагын тогтвортой байдлын асуудлыг шүүхээр хянуулсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад орон нутгийн удирдлагаас эрхийн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан тул нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны зорилго үндсэндээ биелсэн.

Багшлах эрх олгох журамтай холбоотой маргаанд Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Боловсролын сайд захиргааны хэм хэмжээний акт батлахдаа хуульд заасан ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй гэж дүгнэж, журмын биелэлтийг 4 сарын хугацаагаар түдгэлзүүлэн, зөрчлөө арилгах боломж олгож шийдвэрлэсэн. Улсын дээд шүүх хэргийг хянан хэлэлцээд нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах эрхийн хүрээг хязгаарлагдмал байдлаар тайлбарлаж, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон боловч уг маргаан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн хэрэглээ, боловсролын орчин, хүүхдийн чанартай боловсрол эзэмших эрхийн асуудлыг цаашид нэг мөр ойлгож, тайлбарлан хэрэглэх шаардлагатайг харуулсан. Энэхүү үйл ажиллагаа нь боловсролын салбар дахь захиргааны шийдвэр, захиргааны хэм хэмжээний актыг хууль ёсны байдлыг шүүхээр хянуулах, захиргааны байгууллагын эрх хэмжээ, хуульд заасан ажиллагаа, нийтийн ашиг сонирхлын хамгаалалт, боловсролын байгууллагын тогтвортой байдал, хүүхдийн чанартай боловсрол эзэмших эрхийн асуудлыг хууль зүйн үндэслэлтэйгээр хөндсөн стратегийн өмгөөллийн ажил болсон.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:** Энэхүү стратегийн өмгөөллийн үйл ажиллагааг өмгөөлөгч Э.Чулуунцэцэг өөрийн нэрийн өмнөөс бие даан хэрэгжүүлсэн.

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд ажил хэргийн харилцаатай байсан хүмүүс:**

1. **Нэр:** Х.Мөнхцэцэг

**Албан тушаал, байгууллага:** Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын III сургуулийн захирал

**Оролцсон байдал:** Захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр оролцсон

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [munkhtsetseg.khkh@gmail.com](mailto:munkhtsetseg.khkh@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Төв аймаг, Зуунмод сум, [Хүчингүй]

2. **Нэр:** М.Долгион

**Албан тушаал, байгууллага:** “Нэст Эдүкэйшн” сургуулийн нийгмийн ухааны багш

**Харилцааны төрөл:** Багшлах эрх олгох журамтай холбоотой асуудлаар хэвлэлийн бага хурал хамтран зохион байгуулсан.

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [mdolqion3@gmail.com](mailto:mdolqion3@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Сүхбаатар дүүрэг, [Хүчингүй]

3. **Нэр:** Профессор Ц.Лувсандорж

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургуулийн Дидактикийн тэнхимийн эрхлэгч, боловсрол судлаач, Монголын багш нарын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга

**Харилцааны төрөл:** Багшлах эрх олгох журамтай холбоотой асуудлаар хэвлэлийн бага хурал хамтран зохион байгуулсан

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [luvsandorjts@gmail.com](mailto:luvsandorjts@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургууль

## ГУРАВ. ДОКТОРЫН СУДАЛГААНЫ АЖИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮНД ТУЛГУУРЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН САНАЛ ДЭВШҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** 2024 онд “Монгол Улсын ЕБС-ийн багшийн мэргэжлийн эрхийн зохицуулалтад хийсэн судалгаа” сэдвээр МУБИС-д боловсролын удирдлагын докторын судалгааны ажил бичиж, хамгаалсан. Судалгааны үр дүнд тулгуурлан “Багшийн эрх зүйн байдлын тухай хууль” боловсруулах, санаачлах талаар санал дэвшүүлсэн.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Докторын судалгааны хүрээнд мэргэжил, мэргэжлийн бие даасан байдал, мэргэжлийн эрх, багшийн мэргэжлийн эрх, түүний агуулга, хамгаалалтын эрх зүйн үндэслэлийг судалсан. Судалгаагаар үндэсний боловсролын чанар, үр дүн болон багшийн хөгжилд нөлөөлөх чухал хүчин зүйлийн нэг нь багшийн мэргэжлийн эрхийн хамгаалалт болохыг тодруулж, уг эрхийг хамгаалах хууль зүйн арга зам, боломжийг тодорхойлсон.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Судалгааны үр дүнд “Монгол Улсын ЕБС-ийн багшийн мэргэжлийн эрхийн зохицуулалтад хийсэн судалгаа” нэг сэдэвт бүтээлийг боловсруулсан.

Мөн судалгааны үр дүнд үндэслэн “Багшийн эрх зүйн байдлын тухай хууль” боловсруулах, санаачлах саналыг Улсын Их Хурлын Нийтийн цахим өргөдөл, гомдлын системд байршуулсан. Уг саналыг 11,124 иргэн DAN системээр нэвтэрч, цахимаар гарын үсэг зурж дэмжсэн нь боловсролын эрх зүйн судалгааны үр дүнг хууль тогтоомжийн түвшинд дэвшүүлж, олон нийтийн дэмжлэг авсан үр дүн болсон.  
**Эх сурвалж:** Улсын Их Хурлын Нийтийн цахим өргөдөл, гомдлын систем: <https://petition.parliament.mn/Detail?id=c94f18c1-91a1-4fc4-b7bb-4988d92a4973>

### Докторын судалгааны ажлын удирдагч

**Нэр:** Профессор Т.Нэмэхжаргал

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [nemekhjargal@msue.edu.mn](mailto:nemekhjargal@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [Хүчингүй]

### Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс

- Нэр:** Академич Н.Бэгз  
**Албан тушаал, байгууллага:** ШУА-ийн гишүүн, Нийгмийн ухааны салбарын Бага чуулганы дарга  
**Харилцааны төрөл:** Докторын судалгааны ажлын албан ёсны шүүмжлэгч  
**Утас:** [Хүчингүй]  
**Цахим шуудан:** [begznadmid@gmail.com](mailto:begznadmid@gmail.com)  
**Ажлын газрын хаяг:** [Хүчингүй]
- Нэр:** Профессор Д.Наранчимэг  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Боловсролын удирдлагын тэнхимийн эрхлэгч  
**Харилцааны төрөл:** Докторын сургалт хариуцсан тэнхимийн эрхлэгч  
**Утас:** [Хүчингүй]  
**Цахим шуудан:** [naranchimeg@msue.edu.mn](mailto:naranchimeg@msue.edu.mn)  
**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [Хүчингүй]
- Нэр:** Дэд профессор О.Өнөрцэцэг  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн эрх зүйн багш  
**Харилцааны төрөл:** Докторын судалгааны ажлын шүүмжлэгч  
**Утас:** [Хүчингүй]  
**Цахим шуудан:** [unur\\_1206@yahoo.com](mailto:unur_1206@yahoo.com)  
**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн хичээлийн [Хүчингүй]

## ДӨРӨВ. МАГИСТРЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Магистрын түвшний сургалт, судалгааны ажил удирдах, шүүмж бичих, хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох мэргэжлийн үйл ажиллагаа, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, 2024 оноос хойш.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Э.Чулуунцэцэг нь эрдмийн зэрэг хамгаалснаас хойших хугацаанд магистрын түвшний сургалт, судалгааны үйл ажиллагаанд оролцож, магистрантын судалгааны ажил удирдах, шүүмж бичих, судалгааны сэдэв, бүтэц, арга зүйн талаар зөвлөгөө өгөх зэргээр эрх зүйн боловсролын чиглэлийн судалгааны ажлыг дэмжин ажиллаж байна.

Мөн Улс төр, эрх зүйн боловсролын магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцож, магистрын түвшний судалгааны чанар, академик шаардлага, хамгаалалтын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах чиглэлээр ажиллаж байна.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Энэхүү үйл ажиллагаа нь магистрын түвшний судалгаанд эрх зүйн дүн шинжилгээний арга зүй, судалгааны бүтэц, хууль зүйн үндэслэл, академик бичлэгийн шаардлагыг хангахад чиглэсэн. Мөн эрх зүйн боловсрол, боловсролын эрх зүй, хүний эрх, иргэний боловсролын чиглэлээр судалгааны сэдэв хөгжүүлэх, магистрантын судалгааны ажлын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Нэр:** Н.Мягмарцоож

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн захирал, профессор

**Харилцааны төрөл:** Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга

**Утас:** [Redacted]

**Цахим шуудан:** [myagmartsooj@msue.edu.mn](mailto:myagmartsooj@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** Сүхбаатар дүүрэг [Redacted]

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс**

**Нэр:** Дэд профессор О.Өнөрцэцэг

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн эрх зүйн багш

**Харилцааны төрөл:** Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн

**Утас:** [Redacted]

**Цахим шуудан:** [unur\\_1206@yahoo.com](mailto:unur_1206@yahoo.com)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн хичээлийн 2 дугаар байр, 301 тоот

**Нэр:** доктор дэд профессор Э.Гэрэлт-Од

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн улс төр судлалын багш

**Харилцааны төрөл:** Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн

**Утас:** [Redacted]

**Цахим шуудан:** [gereltod.erdenebileg@msue.edu.mn](mailto:gereltod.erdenebileg@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн хичээлийн 2 дугаар байр 107 тоот

**Нэр:** Б.Энхболд

**Албан тушаал, байгууллага:** Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

**Харилцааны төрөл:** Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн

**Утас:** [Redacted]

**Цахим шуудан:** [b.enkhbold8410@gmail.com](mailto:b.enkhbold8410@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, [Redacted]

**ТАВ. МУБИС-ИЙН ЁС ЗҮЙН ХОРООНД АЖИЛЛАСАН БОЛОН ЁС ЗҮЙН ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн салбар ёс зүйн хорооны гишүүн, МУБИС-ийн Төв ёс зүйн хорооны гишүүн, даргаар ажилласан болон багш, ажилтан, судлаачийн ёс зүйн дүрэм боловсруулах үйл ажиллагаа, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, 2017–2025 он.

**Үйл ажиллагааны гол агуулга:** 2017 оноос МУБИС-ийн НХУС-ийн салбар ёс зүйн хорооны гишүүнээр ажиллаж, багш, ажилтны ёс зүйн асуудал, өргөдөл, гомдол, мэдээллийг хэлэлцэх үйл ажиллагаанд оролцсон. 2020 оноос МУБИС-ийн Төв ёс зүйн хорооны гишүүнээр ажиллаж, МУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийн төслийг боловсруулах, салбар сургуулиудаас санал авч нэгтгэх, Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах ажиллагаанд оролцсон.

2022 оноос МУБИС-ийн Төв ёс зүйн хорооны даргаар ажиллаж, удирдах албан тушаалтанд холбогдох ёс зүйн гомдол, мэдээллийг хүлээн авах, тухайн асуудал нь ёс зүйн маргаанд хамаарах эсэхийг урьдчилан шалган тогтоох, хороог хуралдуулах, хурал удирдах чиг үүргийг хэрэгжүүлсэн. Мөн судлаачийн ёс зүйн дүрэм боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, дүрмийн эцсийн найруулга, эрх зүйн уялдаа, хэрэглээний тодорхой байдлыг хянасан.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** МУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулж, байгууллагын хэмжээнд хэлэлцүүлэн батлуулахад хувь нэмэр оруулсан. Тус дүрэм нь багш, ажилтны ёс зүйн харилцаа, байгууллагын дотоод соёл, мэргэжлийн хариуцлага, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тодорхой болгосон.

Мөн Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд өргөдөл, гомдлын харьяаллыг зөв тодорхойлох, талуудын байр суурийг сонсох, ёс зүйн маргаан болон эрх зүйн маргааныг ялгах, бодит нөхцөл байдалд үндэслэн дүгнэлт гаргах зарчмыг баримтлан ажилласан. Энэхүү үйл ажиллагаа нь мэргэжлийн ёс зүй, шударга байдал, хараат бус байр суурь, байгууллагын хариуцлагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн туршлага болсон.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Ажил олгогч:** МУБИС-ийн ректор, профессор Б.Батбаатар

**Хаяг:** МУБИС-ийн хичээлийн [REDACTED]

**Утасны дугаар:** [REDACTED]

**Цахим шуудан:** [batbaatar@msue.edu.mn](mailto:batbaatar@msue.edu.mn)

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд ажил хэргийн харилцаатай байсан хүмүүс:**

- Нэр:** Ш.Дауранбек  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Төв ёс зүйн хорооны одоогийн дарга  
**Харилцааны төрөл:** МУБИС-ийн салбар болон Төв ёс зүйн хорооны үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан.  
**Утас:** [REDACTED]  
**Цахим шуудан:** [daurenbek@msue.edu.mn](mailto:daurenbek@msue.edu.mn)  
**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [REDACTED]
- Нэр:** Профессор Т.Нэмэхжаргал  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш  
**Харилцааны төрөл:** МУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийн төслийг хянасан.  
**Утас:** [REDACTED]  
**Цахим шуудан:** [nemekhjargal@msue.edu.mn](mailto:nemekhjargal@msue.edu.mn)  
**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [REDACTED]
- Нэр:** Н.Баярцэцэг  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны дарга  
**Харилцааны төрөл:** Судлаачийн ёс зүйн дүрмийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч  
**Утас:** [REDACTED]

Цахим шуудан: [bayartsetseg@msue.edu.mn](mailto:bayartsetseg@msue.edu.mn)

Ажлын газрын хаяг: МУБИС-ийн [REDACTED]

## **ЗУРГАА. “АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ” СЭДЭВТ БОДЛОГЫН СУДАЛГАА**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** “Монгол Улсын ахмад настны нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт” судалгааны ажил, Монгол дахь Конрад-Аденауэр сангийн захиалгаар, 2020 он.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Судалгааны хүрээнд Монгол Улсын ахмад настны нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт, ахмад настны нийгмийн баталгаа, халамж, тэтгэвэр, эрүүл мэнд, асаргаа, нийгмийн оролцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судалсан. Мөн ахмад настны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндэсний эрх зүйн орчны давхардал, хийдэл, хэрэгжилтийн хүндрэл, зохицуулалтын уялдаа холбоог шинжилж, ахмад настны нийгмийн хамгааллын зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Судалгааны үр дүнд “Монгол Улсын ахмад настны нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт” судалгааны тайлан боловсруулж, захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Энэхүү судалгаа нь ахмад настны эрх, нийгмийн хамгааллын баталгааг хүний эрхийн зарчимд нийцүүлэн үнэлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, зохицуулалтын уялдаа, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар судалгаанд суурилсан санал, дүгнэлт боловсруулахад чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа болсон. Мөн уг ажил нь нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, хүний эрхэд суурилсан хууль зүйн судалгаа хийх мэргэшлийг харуулсан. **Эх сурвалж:** <https://catalog.parliament.mn/cgi-bin/koha/opac-showmarc.pl?id=30916&viewas=html>

### **Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

/Монгол дахь Конрад-Аденауэр сангийн тухайн судалгааг хариуцсан албан тушаалтны мэдээллээр нөхнө./

1. **Нэр:** Монгол дахь Конрад-Аденауэр сан

**Утас** [REDACTED]

**Цахим шуудан:** [zentrale@kas.de](mailto:zentrale@kas.de)

**Ажлын газрын хаяг:** Монгол дахь [REDACTED]

### **Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс:**

2. **Нэр:** Ц.Баянмөнх

**Албан тушаал, байгууллага:** ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтан

**Харилцааны төрөл:** Судалгааны арга зүй, мэдээлэл цуглуулах, эрх зүйн дүн шинжилгээ хийх хүрээнд хамтран ажилласан.

**Утас:** [REDACTED]

**Цахим шуудан:** [tsebayanmunkh@gmail.com](mailto:tsebayanmunkh@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** Чингэлтэй дүүрэг, [REDACTED]

3. **Нэр:** П.Нямсүрэн

**Албан тушаал, байгууллага:** Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч

**Харилцааны төрөл:** Судалгааны талаар санал солилцож байсан.

**Утас:** [REDACTED]

**Цахим шуудан:** [nyamsuren.purevdorj@judges.mn](mailto:nyamsuren.purevdorj@judges.mn)

**Ажлын газрын хаяг:** Налайх дүүрэг, [REDACTED]

**ДОЛОО. ЕБС-ИЙН “НИЙГМИЙН СУДАЛ” ХИЧЭЭЛИЙН ҮНДЭСНИЙ СУРАХ БИЧИГ, БАГШИЙН НОМЫН ЭРХ ЗҮЙН БҮЛЭГ СЭДВИЙН ЗОХИОГЧООР АЖИЛЛАСАН**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Ерөнхий боловсролын сургуулийн “Нийгмийн судлал” хичээлийн үндэсний сурах бичиг, багшийн номын эрх зүйн бүлэг сэдвийн зохиогчоор ажилласан, 2014–2018 он.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрх зүйн суурь мэдлэг, хүний эрх, үүрэг, хууль дээдлэх ёс, иргэний оролцоо, эрх зүйн соёлын ойлголтыг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хүргэх зорилгоор “Нийгмийн судлал” үндэсний сурах бичиг болон багшийн номын эрх зүйн бүлэг сэдвийг боловсруулсан.

Энэ хүрээнд 7 дугаар ангийн “Нийгмийн ухаан-1” үндэсний сурах бичгийн эрх зүйн бүлэг сэдвийг хоёр удаа шинэчлэн боловсруулах, багшийн номын эрх зүйн бүлэг сэдэв боловсруулах, мөн 11 дүгээр ангийн “Нийгмийн судлал” үндэсний сурах бичгийн эрх зүйн бүлэг сэдвийг боловсруулах ажилд оролцсон.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Үндэсний сурах бичиг, багшийн номд эрх зүйн бүлэг сэдэв боловсруулснаар ЕБС-ийн сурагчдын эрх зүйн боловсрол, хүний эрхийн ойлголт, иргэний үүрэг, хууль дээдлэх ёсны мэдлэгийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулсан.

Энэхүү ажил нь эрх зүйн мэдлэгийг зөвхөн мэргэжлийн хуульчдын хүрээнд бус, ерөнхий боловсролын түвшинд хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр түгээсэн, үндэсний хэмжээнд хэрэглэгдсэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах мэргэжлийн үйл ажиллагаа болсон.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Сурах бичгийн зохиогчдын багийн ахлагч**

**Нэр:** Профессор Т.Нэмэхжаргал

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш

**Харилцааны төрөл:** Арга зүйн заавар, зөвлөгөө өгсөн.

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [nemekhjargal@msue.edu.mn](mailto:nemekhjargal@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [Хүчингүй]

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс:**

- Нэр:** Р.Дарьхүү  
**Албан тушаал, байгууллага:** МУИС-ийн Философийн тэнхимийн эрхлэгч  
**Харилцааны төрөл:** 7 дугаар ангийн сурах бичгийн “Ёс зүй” бүлэг сэдвийн зохиогч  
**Утас:** —  
**Цахим шуудан:** [renchin\\_darikhuu@yahoo.com](mailto:renchin_darikhuu@yahoo.com)  
**Ажлын газрын хаяг:** МУИС- [Хүчингүй]
- Нэр:** Н.Мягмарцоож  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн НХУС-ийн захирал, профессор  
**Харилцааны төрөл:** 11 дүгээр ангийн сурах бичгийн “Улс төр” бүлэг сэдвийн зохиогч  
**Утасны дугаар:** [Хүчингүй]  
**Цахим шуудан:** [myagmartsooj@msue.edu.mn](mailto:myagmartsooj@msue.edu.mn)  
**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [Хүчингүй]

**Найм. “Эрх зүйн онол” гарын авлага бичиж сургалт, судалгааны эргэлтэд оруулсан**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** “Эрх зүйн онол” гарын авлага бичиж, хэвлүүлсэн үйл ажиллагаа, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, 2017 он.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Эрх зүйн онолын үндсэн ойлголт, эрх зүйг тодорхойлох түүхэн болон орчин үеийн үзэл хандлага, эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн харилцаа, эрх зүйн эх сурвалж, хууль хэрэглэх, хууль тайлбарлах, хууль зүйн хариуцлага зэрэг суурь асуудлыг нэгтгэн боловсруулж, эрх зүйн сургалтад ашиглах зориулалттай гарын авлага бэлтгэсэн.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** “Эрх зүйн онол” гарын авлагыг 2015 оноос хойш нийт 3300 хувь хэвлүүлэн, сургалт, судалгааны эргэлтэд оруулж, багш бэлтгэх болон хууль зүйн сургуулийн оюутан, ЕБС-ийн багш нарын сургалтад түгээмэл ашиглаж байна.

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүн:**

**Нэр:** Профессор Т.Нэмэхжаргал

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш

**Харилцааны төрөл:** Гарын авлагыг редакторлосон.

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [nemekhjargal@msue.edu.mn](mailto:nemekhjargal@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн хичээлийн 2 дугаар байр, 301 тоот

**ЕС. “Их сургуулийн бие даасан байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт магистрын судалгаа, мэргэжил дээшлүүлэлт, эрх зүйн баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** “Их сургуулийн бие даасан байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт магистрын судалгааны ажил, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2011 он; их сургуулийн засаглал, бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчны чиглэлээр мэргэжил дээшлүүлэлт болон эрх зүйн баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа, 2015 оноос хойш.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Магистрын судалгааны хүрээнд их сургуулийн бие даасан байдал, академик эрх чөлөө, их сургуулийн засаглал, төрийн өмчийн их сургуулийн эрх зүйн байдал, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтын асуудлыг судалсан.

Уг судалгааны чиглэлээ үргэлжлүүлэн 2015 онд Япон Улсын Токио хотын Gakugei их сургууль, Komazawa эмэгтэйчүүдийн их сургууль, Токиогийн Гадаад судлалын их сургууль, Showa эмэгтэйчүүдийн их сургууль, Oberlin их сургуулийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрх зүйн орчны туршлагыг судалсан. Мөн 2016, 2017 онд БНСУ-ын Чоннам Үндэсний их сургуульд боловсролын удирдлагын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Магистрын судалгаа болон гадаадын их сургуулиудын засаглал, эрх зүйн орчны туршлагыг судалсан мэдлэгтээ тулгуурлан төрийн өмчийн их сургуулийн эрх зүйн байдал, засаглал, зохион байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажилласан. Тухайлбал, Боловсролын яамны “Төрийн өмчийн их сургуулийн дүрэм”-ийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд оролцож, төрийн өмчийн их сургуулийн бүтэц, удирдлага, академик эрх чөлөө, бие даасан байдал, дотоод засаглалын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох ажилд хувь нэмэр оруулсан. Мөн “Судалгааны их сургуулийн тухай хууль”-ийн төсөл боловсруулах ажилд оролцсон.

Энэхүү үйл ажиллагаа нь магистрын судалгааны үр дүнг мэргэжил дээшлүүлэх болон эрх зүйн баримт бичиг боловсруулах практик үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлсэн, их сургуулийн засаглал, академик эрх чөлөө, төрийн өмчийн их сургуулийн эрх зүйн орчны чиглэлээр мэргэшсэн байдлыг харуулсан ажил болсон.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Нэр:** П.Одгэрэл

**Албан тушаал, байгууллага:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Захиргааны эрх зүйн тэнхимийн багш, доктор, профессор

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:**

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс:**

1. **Нэр:** Доктор Т.Туяачимэг

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн улс төр судлалын багш

**Харилцааны төрөл:** Япон Улсад мэргэжил дээшлүүлэх, их сургуулийн засаглалын туршлага судлах үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан.

**Утас:** [Хүчингүй]

**Цахим шуудан:** [t.tuyachimeg@gmail.com](mailto:t.tuyachimeg@gmail.com)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [Хүчингүй]

2. **Нэр:** Доктор, профессор Я.Шийлэгмаа  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Боловсролын судалгааны хүрээлэнгийн захирал  
**Харилцааны төрөл:** Их сургуулийн дүрмийн төслийн багт хамтран ажилласан.  
**Утас:** [REDACTED]

**Цахим шуудан:** [shiilegmaa@msue.edu.mn](mailto:shiilegmaa@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** Сүхбаатар дүүрэг, [REDACTED]

3. **Нэр:** Профессор, Монгол Улсын гавьяат багш Ц.Баасандож  
**Албан тушаал, байгууллага:** Тухайн үед МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургуулийн захирал, одоогоор тэтгэвэрт гарсан  
**Харилцааны төрөл:** “Төрийн өмчийн их сургуулийн дүрэм” болон их сургуулийн эрх зүйн орчны баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд ажил хэргийн харилцаатай байсан.

**Утас:** [REDACTED]

**Цахим шуудан:** [baasandorj@msue.edu.mn](mailto:baasandorj@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** Сүхбаатар дүүрэг, [REDACTED]

### **АРАВ. ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Эрх зүйн боловсролын бакалаврын хөтөлбөр, сургалтын агуулга, стандарт боловсруулах, хэрэгжүүлэх болон бакалаврын түвшний сургалт, судалгааны ажилд оролцсон үйл ажиллагаа, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, 2008 оноос хойш.

**Үйл ажиллагааны гол агуулга:** 2008 оноос МУБИС-д эрх зүйн багшаар ажиллах хугацаандаа бакалаврын түвшний эрх зүйн хичээлийн хөтөлбөр, стандарт, силлабус, сургалтын агуулга, үнэлгээний арга зүй боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажилд оролцсон.

Эрх зүйн онол, Боловсролын эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүй, Хүний эрх, Эрх зүйн боловсролын чиглэлийн хичээлүүдийн агуулгыг хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгууртай уялдуулан боловсруулж, холбогдох хөтөлбөрийн салбар, дэд, ерөнхий хорооны хурлаар хэлэлцүүлэх, санал авах, засвар тусгах, батлуулах ажиллагаанд оролцсон. Мөн бакалаврын түвшний оюутны судалгааны ажилд удирдагч, шүүмжлэгч, зөвлөх багшаар оролцож ирсэн. Багшлах хугацаандаа нийт 27 бакалаврын дипломын ажлыг удирдаж, оюутны судалгааны сэдэв сонгох, бүтэц боловсруулах, эрх зүйн эх сурвалж ашиглах, хууль зүйн дүн шинжилгээ хийх, судалгааны арга зүй, бичлэгийн шаардлагыг хангах чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.

**Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ:** Энэхүү үйл ажиллагааны үр дүнд МУБИС-ийн бакалаврын түвшний сургалтад эрх зүйн мэдлэг, хууль хэрэглэх чадвар, хүний эрх, хууль дээдлэх ёс, иргэний боловсролын агуулгыг системтэй олгох нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Мөн эрх зүйн боловсролын бакалаврын хөтөлбөрийн чанар, сургалтын агуулгын уялдаа, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, оюутны судалгааны ажлын чанар, эрх зүйн дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэх чиглэлээр ажилласан.

**Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтан:**

**Нэр:** Профессор Т.Нэмэхжаргал

**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш

**Харилцааны төрөл:** Тэнхимийн эрхлэгч байсан

**Утас:** [REDACTED]

**Цахим шуудан:** [nemekhjargal@msue.edu.mn](mailto:nemekhjargal@msue.edu.mn)

**Ажлын газрын хаяг:** МУБИС-ийн [REDACTED]

**Тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан хүмүүс:**

1. **Нэр:** Дэд профессор О.Өнөрцэцэг  
**Албан тушаал, байгууллага:** МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн эрх зүйн багш

	<p><b>Харилцааны төрөл:</b> Хөтөлбөрийн салбар, дэд, ерөнхий хорооны хэлэлцүүлэг, санал авах, засвар тусгах ажиллагааны хүрээнд хамтран ажилласан.  <b>Утас:</b> [REDACTED]  <b>Цахим шуудан:</b> unur_1206@yahoo.com  <b>Ажлын газрын хаяг:</b> Сүхбаатар дүүрэг, [REDACTED]</p> <p>2. <b>Нэр:</b> Доктор А.Гандолгор  <b>Албан тушаал, байгууллага:</b> МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн багш  <b>Харилцааны төрөл:</b> Хичээлийн стандартуудыг нэгтгэх, эмхэтгэх, хэвлүүлэх ажлын хүрээнд хамтран ажилласан.  <b>Утас:</b> [REDACTED]  <b>Цахим шуудан:</b> gandolgor@msue.edu.mn  <b>Ажлын газрын хаяг:</b> Сүхбаатар дүүрэг, [REDACTED]</p> <p>3. <b>Нэр:</b> С.Энхчимэг  <b>Албан тушаал, байгууллага:</b> МУБИС-ийн НХУС-ийн Хөтөлбөрийн албаны мэргэжилтэн  <b>Харилцааны төрөл:</b> Стандарт, хөтөлбөрийн үнэлгээ, шинжилгээ хариуцан ажиллах хүрээнд хамтран ажилласан.  <b>Утас:</b> [REDACTED]  <b>Цахим шуудан:</b> enkhchimeg@msue.edu.mn  <b>Ажлын газрын хаяг:</b> Сүхбаатар дүүрэг, [REDACTED]</p>
4.2	Хавсралтад дэлгэрэнгүй байдлаар оруулсан
4.3	Хавсралтад дэлгэрэнгүй байдлаар оруулсан
4.4	3 дугаар бүлэгт тайлбар баримтууд оруулсан
4.5	<p><b>Сахилгын шийтгэл</b>  Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

**Хавсралт:**

- Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:
- төрийн албан хаагчийн анкет;
  - иргэний үнэмлэхийн хуулбар;
  - нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
  - эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
  - хууль зүйн өндөр мэргэжилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
  - эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
  - энэхүү загварт заасан баримт бичиг;
  - холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Эрдэнэцогт  
Өөрийн нэр: Чулуунцэцэг  
Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: .....